

**“ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН 2023-2024 ОНЫ ХАМТ
/ТАРИФ/-ЫН ХЭЛЭЛЦЭЭР”-Т ОРУУЛАХ
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮД**

Энэхүү хамт /тариф/-ын хэлэлцээр нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцэж байгаа тул 2025 оны 5 сарын 9-ны өдөр бүртгэв.

Бүртгэлийн дугаар.....

Улаанбаатар хот
2025 он

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН 2023-2024 ОНЫ ХАМТ /ТАРИФ/-ЫН ХЭЛЭЛЦЭЭР"-Т ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТҮҮД

Эрчим хүчний яам, Үйлдвэрчний эвлэлийн холбоод, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо нь /цаашид талууд гэх/ Хөдөлмөрийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.7, 34 дүгээр зүйлийн 34.1.2 дах хэсгийг тус тус үндэслэн эрчим хүчний салбарын ажилтны хөдөлмөрлөх эрх, нийгмийн хамгаалалтай холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хамтран хамгаалах зорилгоор Эрчим хүчний салбарын 2023-2024 оны хамт /тариф/-ын хэлэлцээр"-ийн /нийтлэг үндэслэл, 1.2, 1.5, 3.1, 3.2, 3.3, 3.4, 3.5, 3.6, 3.8, 3.10, 3.11, 3.14, 3.16, 8.3/, /3.22, 3.23, 3.24, 3.25, 3.26, 3.27, 3.28 гэж нэмэх/ дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулахаар тогтов.


НЭГ. Монгол улсын "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, "Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, "Хөдөлмөрийн тухай" хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 33 дугаар зүйлийн 33.1, 34 дүгээр зүйлийн 34.1.2, 36 дугаар зүйлийн 36.1.2 дахь заалтуудыг үндэслэн Эрчим хүчний яам, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн холбоодоос энэхүү хамт/тариф/-ын хэлэлцээрийг байгуулж байна. Хэлэлцээрийн зорилго нь өмчийн хэлбэр харгалзахгүйгээр Эрчим хүчний салбарын хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж баталгаажуулах, ажилтнуудын нийгмийн хамгааллын асуудлыг дэс дараатай шийдвэрлэх, үйлдвэрлэлийн үр ашигтай, тогтвортой үйл ажиллагааг хангахад оршино. "Эрчим хүчний яам, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн холбоодоос энэхүү хамт/тариф/-ын хэлэлцээрийг байгуулж байна".

ХОЁР. "Салбарын аж ахуйн нэгжийн захиргаа, ҮЭ-ийн хороо хамтын гэрээний биелэлтийн мэдээг батлагдсан хүснэгтийн дагуу хагас, бүтэн жилээр Эрчим хүчний яам, ҮЭ-ийн холбоодод заавал тайлагнана.

ГУРАВ. Хэлэлцээрийн заалтуудыг биелүүлэх эдийн засгийн үндэс нь ажил олгогчдын санхүүгийн чадавх тул салбарын аж ахуйн нэгжүүд орлого, ашгаа нэмэгдүүлэхэд Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, ҮЭ-ийн холбоод (цаашид салбарын ҮЭ-ийн холбоод гэх), мэргэжлийн холбоод Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд бодлого, шийдвэрээрээ дэмжинэ".

ДӨРӨВ. Салбарын аж ахуйн нэгж, компани бүр хэрэглээний үнийн индекс, үйлдвэрлэлийн үр ашиг, үнэ, тарифын өсөлт, эрчим хүчний алдагдал, өр авлагын бууралт, батлагдсан зардлын хэмнэлт, Хөдөлмөр нийгмийн түншлэлийн улсын 3 талт хэлэлцээрийг үндэслэн ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмж, ажлын ачааллыг харгалзан албан тушаалын үндсэн ба тарифт цалинг 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 10-15 түүнээс дээш хувиар нэмэгдүүлнэ.

2026 оны цалин хөлсний нэмэгдлийг 2025 оны 10 сарын 30-ны дотор нэмэлт хэлэлцээрээр тохирно. Салбарын аж ахуйн нэгж, компанийн цалингийн сан болон албан тушаалын үндсэн ба тарифт цалинг нэмэгдүүлэх асуудлыг захиргаа, ҮЭ-ийн хороо хамтран шийдвэрлэнэ.



ТАВ. Эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь Хөдөлмөр нийгмийн түншлэлийн 3 талт үндэсний хорооноос тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 1.7 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна. Салбарын аж ахуйн нэгж байгууллагууд нь Эрчим хүчний салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг ажилтан, албан хаагчдын өндөр насны тэтгэвэр тогтоолгох, нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх, мөнгөн шагнал олгоход хэрэглэнэ.

ЗУРГАА. Салбарын аж ахуйн нэгж байгууллагууд нь байгууллагын хүчин чадал, эдийн засгийн чадавхиас хамаарч Хөдөлмөр Нийгмийн түншлэлийн Гурван Талт Үндэсний хорооноос тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дараах итгэлцүүр хүртэлх хэмжээгээр үржүүлж тооцно. Салбарын хэмжээнд төсөвт ажил гүйцэтгэхэд тарифыг аж ахуйн нэгж бүр дагаж мөрдөнө. Итгэлцүүр хүртэлх гэсэн хэмжээг 2025- 2026 оны хамт /тариф/-ын хэлэлцээрт хасахаар хэлэлцэнэ. "ББЭХС" болон "АУЭХС" ТӨХК-ийг итгэлцүүрийн 2 дах жагсаалтад, "Амгалан ДС", "ДэДЦС" ТӨХК-ийг итгэлцүүрийн 3 дах жагсаалтад тус тус нэмнэ/.

ДОЛОО. Ажил мэргэжлийн стандарт, Ажил, ажилчдын түгээмэл мэргэжлийн тариф мэргэшлийн лавлахыг Эрчим хүчний яам, Салбарын ҮЭ-ийн холбоо болон мэргэжлийн холбоод хамтран боловсруулж, хянаж мөрдүүлэх бөгөөд ажил олгогч батлагдсан орон тоогоо үндэслэн инженер техникийн ажилтнуудын "Ажлын байрны тодорхойлолт", "Ажил, ажилчдын мэргэжил, тариф мэргэшлийн лавлах"- ыг шинэчлэн боловсруулж, батлан мөрдөнө.


НАЙМ. Аж ахуйн нэгж байгууллагуудын ажлын байранд ээлжээр ажилладаг ажилтнуудад шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг дундаж цалин хөлснөөс 1.35 дахин нэмэгдүүлж олгоно. Өдрөөр ажилладаг ажилтан шөнийн цагаар ажилласан тохиолдолд нэгэн адил хамаарна.

ЕС. Байгууллагын тухайн жилийн зорилго, зорилтын биелэлт, ажлын үр дүн, санхүүгийн ашиг, эдийн засгийн тогтвортой байдлыг харгалзан 3 ба түүнээс дээш сарын албан тушаалын үндсэн ба тарифт цалинтай тэнцэх хэмжээний урамшууллын санг эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн тогтооно. Тухайн ажилтан албан хаагчийн жилийн ажлын үр дүнг харгалзан 5 хүртэлх сарын албан тушаалын үндсэн ба тарифт цалинтай тэнцэх хэмжээний жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг тогтоосон санд багтаан олгож болно.

АРАВ. Сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс, цалинг тухайн сарын үйлдвэрлэлийн найдвартай, аюулгүй ажиллагаа, үр ашиг, эрчим хүчний хэмнэлт зэрэг шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэл үр дүнд үндэслэн тухайн хамт олны /үйлдвэрийн цех хэлтэс, албадын/ албан тушаалын үндсэн болон тарифт цалингийн 50 хүртэл хувиар бодож олгоно. /Хувь хүнд олгох шагналын хэмжээг хязгаарлахгүй/.

АРВАН НЭГ. Эрчим хүчний салбарт ажиллаж байгаа ажилтанд ажилласан жилийн нэмэгдлийг тус салбарт ажилласан хугацаанаас нь хамааруулан хөдөлмөрийн хэвийн нөхцөлд үндсэн цалингийн 35 хүртэл, хэвийн бус нөхцөлд үндсэн цалингийн 40 хүртэл хувиар бодож олгоно.

АРВАН ХОЁР. Ажилтанд хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин хөлсийг сард хоёроос доошгүй удаа тогтоосон хугацаанд олгож байна.



АРВАН ГУРАВ. Эрчим хүчний тэргүүний ажилтанд сар бүр 15,000 төгрөгийн нэмэгдэл урамшууллыг жилээр нь тооцож нэг удаа олгоно.

АРВАН ДӨРӨВ. Эрчим хүчний яам, салбарын ҮЭ-ийн холбооноос хамтран олгож байгаа "Тэргүүний мастер" цол тэмдгээр шагнагдсан ажилтанд 100,000 /нэг зуун мянган/ төгрөгөөс доошгүй дагалдах урамшууллыг үйлдвэрчний эвлэлийн хороо нь олгоно.

АРВАН ТАВ. Ээлжээр ажилладаг ажилтны ээлж, нийтээр амрах баярын өдөр таарвал, түүний дундаж цалин хөлсийг 2 дахин нэмэгдүүлж олгоно.

АРВАН ЗУРГАА. Ажилтан ажил олгогчийн заасан байршилд хүлээсэн бол үндсэн цалингийн 60-аас, бусад тохиолдолд 40-өөс доошгүй хувийн олговрыг олгоно.

АРВАН ДОЛОО. Ажил олгогч нийт ажилтны цалин хөлс, олговор, нэмэгдэлд өөрчлөлт оруулах тохиолдол бүрт шийдвэр гаргахаас ажлын 10 хоногийн өмнө ҮЭХ-нд мэдэгдэж, саналыг авч өөрчлөлт оруулна.


АРВАН НАЙМ. Хээрийн болон орон нутгийн нэмэгдлийг олгох асуудлыг хамтын гэрээндээ тусгаж хэрэгжүүлж болно.

АРВАН ЕС. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтнуудад нөхцлийн нэмэгдэл олгож болно.

ХОРЬ. Эрчим хүчний салбарт төсөв зохиох аргачлалыг холбогдох байгууллагууд болон төр, хувийн хэвшил хамтран боловсруулна.

ХОРИН НЭГ. Эрчим хүчний салбарын цалин хөлсний жишиг аргачлалыг боловсруулна.

ХОРИН ХОЁР. Эрчим хүчний яам, ҮЭ-ийн холбоод, ЭХА-ийн удирдлага, бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөх, мөн шинэчлэн зохион байгуулагдах нь энэхүү хэлэлцээрийг үргэлжлүүлэн мөрдөж хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.



Эрчим хүчний сайдын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/73 дугаар тушаалаар эрх олгогдсон төрийн захираганы төв байгууллагын төлөөлөгчид:

Төлөөлөгчдийн ахлагч
ЭХЯ-ны ЭХБХЗГ-ын дарга

Б.Насантогтох

Төлөөлөгчид:

Эрчим хүчний сайдын зөвлөх

Ц.Цэнгэл

ЭХЯ-ны ТЗУГ-ын дарга

Ж.Хичээнгүй

ЭХЯ-ны БТГ-ын дарга

Б.Ерэн-Өлзий

ЭХЯ-ны СХОГ-ын дарга

О.Хуягцогт

ЭХЯ-ны ХШУДАГ-ын дарга

Х.Бекболат

ЭХЯ-ны СХГ-ын дарга

П.Билгүүн

ЭХЯ-ны ТЗУГ-ын салбарын хүний

нөөцийн бодлого, сураглт хариуцсан

шинжээч

Д.Оюунчимэг

Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн үз-ийн холбооны Тэргүүлэгчдийн хурлын 2025 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 11 тоот тогтоолоор эрх олгогдсон салбарын ажилчдын төлөөлөгчид:

Төлөөлөгчдийн ахлагч

МЭХГУУ-н үз-ийн холбооны ЭХС

хариуцсан нарийн бичгийн дарга

Д.Эрдэнэбат

Төлөөлөгчид:

МЭХГУУ-н үз-ийн холбооны нарын

бичгийн дарга

А.Дагвадорж

"ДЦС-3" ТӨХК-ийн үз-ийн хорооны

дарга

Ш.Энхсаран

"ЦДҮС" ТӨХК-ийн үз-ийн хорооны

дарга

Ц.Мөнхбаатар

"ДСЦТС" ХХК-ийн үз-ийн хорооны

дарга

Г.Баяржаргал

"УБЦТС" ТӨХК-ийн үз-ийн хорооны

дарга

Н.Балжинням

"Дарханы ДЦС" ТӨХК-ийн үз-ийн

хорооны дарга

Ж.Хүдэр

"Улаанбаатар ДС" ТӨХК-ийн үз-ийн

хорооны дарга

Г.Дашдаржаа

"Алтай-Улиастай ЭХС" ТӨХК-ийн үз-ийн

хорооны дарга

Б.Мягмардаш

Дулаан цахилгаан үйлдвэрлэгч түгээгчдийн үйлдвэрчний эвлэлийн холбооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн "Хэлэлцээрийн тухай" албан бичгээр ирүүлсэн салбарын ажилчдын төлөөлөгчид:

ДЦУТ-ийн холбооны дарга

Э.Адъяасүрэн

Төлөөлөгчид:

"ДБЭХС" ТӨХК-ийн үз-ийн дарга

Д.Гунсмаа

"ДЦС-4" ТӨХК-ийн үз-ийн дарга

Д.Ган-Эрдэнэ

"ЭДЦС" ТӨХК-ийн үз-ийн дарга

П.Баттөр

"ДЦУТ"-ийн холбооны хуульч

С.Сэргэлэн

"Хасуутагават" ХХК-ийн үз-ийн

дарга

Б.Ариунбаатар

"БДС" ТӨХК-ийн үз-ийн дарга

Б.Даваацэцэг

"Сүхбаатар эрчим хүч" ТӨХК-ийн

үз-ийн дарга

Х.Ууган-Эрдэнэ

"ДЦС-4" ТӨХК-ийн үз-ийн тэргүүлэгч

Э.Ганзориг

Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны болон Монголын Эрчим хүчний ассоциацийн ерөнхийлөгчдийн 2024 оны 12 дугаар сарын 30-ны 02/222 тоот албан бичгээр ирүүлсэн салбарын ажил олгогч эздийн төлөөлөгчид:

МУХАУТ-ын дэргэдэх Эрчим хүчний зөвлөлийн дарга

Д.Ганхуяг

Төлөөлөгчид:

МЭХБЗХЗ-ын дарга

Г.Цэцэгт

"МЭЗ" ТӨХК-ийн Ерөнхий

захирагч

Д.Ганбаатар

"ДЦС-4" ТӨХК-ийн үйлдвэрлэл

Д.Ганбаатар

"ДБЭХС" ТӨХК-ийн Ү.Төмөрхуяг

захирагч

"УБЦТС" ТӨХК-ийн Гүйцэтгэх

захирагч

К.Эрдэнэбаяр

"ЦДҮС" ТӨХК-ийн Гүйцэтгэх-захирагч

Б.Дашдаваа

"М Си Эс Интернэйшнл" ХХК-ийн

Ерөнхий захирагч

Д.Даваахүү

"Эрчим" иржүүлэгч

Ерөнхий захирагч

М.Батболд

"Налайхын Дулааны станц" ТӨХК-ийн

Гүйцэтгэх захирагч

Ц.Энхтүвшин

ХАРААГАР, НИЙГЭМИЙН
ХАРААГАРЫН АЖАЛ
ХАРААГАРЫН БҮСЭТЭЭ